

ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2023 оны 4-р сарын 30

№ ХЭХ 23/1

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2023 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын № ТК-23/1 тоот шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.
2. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Я. Отгонжаргал/ -д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



/HE JINGWEN/

ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2023 оны 4-р сарын 30

№ ХЭХ 23/2

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах тухай

Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын ТК-23/1 тоот тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг дараах байдлаар баталсугай.

- Цалин 3,600,000
- Хурал зохион байгуулах зардал 600,000

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН

ХУРЛЫН ДАРГА



/HE JINGWEN/

ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2023 оны 4-р сарын 30

№ ТК 23/1

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 сарын 30-ны өдрийн
ээлжит хурлын ирц, хурлыг хүчин төгөлдөрт
тооцох болон санал хураалтын дүнгийн тухай*

Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.1 дэх заалт, 67-р зүйлийн 67.3.8 дах заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь хурлын тооллогын комиссын гишүүнээр томилогдоогүйг дурьдсугай.

ХОЁР. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 71,877 ширхэг хувьцаа эзэмшдэг гурван хувьцаа эзэмшигч саналаа өгсөн нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 99.6 хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

ГУРАВ. Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 99.6 хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ДӨРӨВ. 2022 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлахыг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар зөвшөөрсөн болохыг мэдэгдсүгэй.

ТАВ. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн 2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлахыг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар зөвшөөрсөн болохыг мэдэгдсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



/Н. Алтанзул/